

“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Цогтцэций сум

“Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 сарын 28-ны өдрийн 11:00 цагт Өмнөговь аймаг Цогтцэций сум, Цагаан-овоо 3-р баг, “Тавантолгой” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хурлын дэгийн дагуу 10:10 хүртэл ирц бүртгэсэн.

Хурлын ирц: Тооллогын комиссын дарга С.Дөлгөөн танилцуулснаар:

“Тавантолгой” ХК-ийн саналын эрхтэй нийт 52,665,200 ширхэг хувьцаанаас 94.72% буюу 49,884,064 ширхэг хувьцаа эзэмшиж буй 20 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа нь нийт саналын эрхтэй 52,665,200 ширхэг энгийн хувьцааны 94.72% болж байна. Иймд “Компанийн тухай” хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дах заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдэд компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан бүхий товхимол, хувьцаа эзэмшигчдийн хурлын материал/ хувьцаа эзэмшигчдийн хурал зарласан ТУЗ-ийн тогтоол, хэлэлцэх асуудлын жагсаалт, хурлын дэг, үйл ажиллагааны тайлан тогтоолын төслүүд, саналын хуудас/ -ыг өгсөн болно.

Хурлыг нээж хурал даргалагч Ш.Отгонбаяр үг хэлж, хэлэлцэх асуудлыг танилцууллаа. ТУЗ-ийн 2025 оны 03 сарын 17-ны өдрийн хурлын 15 тоот тогтоолоор батлагдсан хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тооллогын комиссын бүрэлдэхүүнийг танилцууллаа. Үүнд:

1. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах
2. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. “Тавантолгой” ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах
4. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай

Хэлэлцсэн нь: Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу асуудлыг хэлэлцлээ.

Хэлэлцэх асуудал № 01 “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх тухай. Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулгаа. /хавсралт/

Хэлэлцэх асуудал № 02 “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэх тухай

Хурал даргалагч Ш.Отгонбаяр Компанийн санхүүгийн үзүүлэлт болон 2025 оны 04-р сарын 24-ний өдөр хуралдсан Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 20 тоот тогтоолыг уншиж танилцуулгаа. /хавсралт/

Хувьцаа эзэмшигч Н.Отгонбаяр: Тайлан мэдээллийг сонслоо. Ганц хоёр зүйл тодруулж асууя. Гүйцэтгэх захирал бол санхүүгийн биш үйл ажиллагааны тайлан танилцуулгаа гэж ойлголоо. Санхүүгийн тайланг дэлгэрэнгүй танилцуулах уу? Мөн ТУЗ-ийн дүгнэлт дээр 2024 онд компанийн үйл ажиллагаа сайжирсан гэж байна. Энэ одоо юу гэсэн үг вэ? Ийм дүгнэлт байдаг юмуу. Хурлын материал сая л авлаа. Оройтож өгч байна. Энэ материалд аудитын дүгнэлт гараагүй байгаа гээд гэсэн байна. Төрийн аудитын газраас хязгаарлалттай дүгнэлт өгсөн гэлээ. Ямар асуудлаас болоод хязгаарлалттай дүгнэлт авсан вэ? гэдгийг дэлгэрэнгүй тайлбарлах хэрэгтэй байна.

Хурал даргалагч Ш.Отгонбаяр: Хурлын материалын хувьд хуулийн хугацаанд брокер диллерийн компаниудад хүргэгдсэн байгаа. Санхүүгийн аудитын дүгнэлтийн хувьд энэ жил хязгаарлалттай дүгнэлт авсан. Өнгөрсөн жил сөрөг дүгнэлт авсан. 2022, 2023 онд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээл үүссэн. Энэ талаар өнгөрсөн жилийн хувьцаа эзэмшигчдийн хурал дээр мэдээлж байсныг та бүхэн мэдэж байгаа байх. Ерөнхий нягтлан бодогч, нягтлангууд 2-3 удаа солигдсон, мөн программ хангамж солигдож олон хүндрэл бэрхшээл үүссэн. ТУЗ, гүйцэтгэх удирдлага, санхүүгийн албаныхан маань бүгд санхүүгийн үйл ажиллагаанд үүссэн алдаа, дутагдал, хүндрэл бэрхшээлийг арилгахын тулд хичээж ажилласан. Өнгөрсөн 9-р сард ТУЗ-өөс хуулийн дагуу хөндлөнгийн аудитын байгууллагыг хуулийн дагуу сонгон шалгаруулсан. Монголын топ аудитын байгууллагууд руу урилга, ажлын даалгавар явуулж, ирсэн саналыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо хянаж “Солид юнити аудит” ХХК-ийг сонгон шалгаруулсан. 2 сар гаруй хугацаанд аудит хийсэн. Аудитын ажлын тайлан, дүгнэлтийг ТУЗ хэлэлцэж, компанийн гүйцэтгэх удирдлага, санхүүгийн албаны ажилтнуудад тодорхой үүрэг чиглэл өгч ажилласан. 2024 оны санхүүгийн тайланд Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийсэн. Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар “Солид юнити аудит ХХК-ийн туслан гүйцэтгэгчээр авч ажиллуулсан. Энэ асуудалд компани ТУЗ оролцоогүй. Аймгийн Төрийн аудитын газар өөрсдөө сонгосон. Аудитын дүгнэлт, тайлан 4-р сарын 24-нд хуралдсан ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн. ТУЗ дүгнэхдээ өмнөх жилийнхээс алдаа зөрчлийн тоо буурч, компанийн санхүүгийн тайлагналын тогтворжсон байна гэж дүгнэсэн. Бид бүх зүйл сайн боллоо гэж дүгнээгүй, өнгөрсөн жилээс ямартай ч ахиц гарсан, тайлагнал тогтворжиж байна гэдгийг илэрхийлсэн.

Санхүүгийн тайлагналаа илүү сайжруулахад чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлаа ТУЗ болон гүйцэтгэх удирдлагатай хамтран төлөвлөн ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч Болдбаатар: Тайлан мэдээлэлтэй танилцлаа. Компанийн үйл ажиллагаа сайн байна гэж дүгнэж байна. Зорилтот түвшиндээ хүрээгүй ашигт ажиллагааны түвшин боломжийн гэж үзсэн байна. Үүнтэй санал нэг байна. 2025 онд зах зээлийн нөхцөл байдал хүнд байгааг ойлгож байна,

Хэлэлцэх асуудал №03 “Тавантолгой” ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай

Хурал даргалагч Ш.Отгонбаяр компанийн 2023 оны цэвэр ашгийн ногдол ашгийг тараасан товч тайланг танилцууллаа /хавсралт/

Санал, асуулт хариулт

Хувьцаа эзэмшигч Н.Отгонбаяр: 2023 оны ногдол ашиг бүрэн тараагдсан гэж байна. Миний ойлгож байгаагаар ногдол ашгаа авч чадаагүй олон хувьцаа эзэмшигчид байдаг. Бүрэн тараагдсан гэдгийг тайлбарлах хэрэгтэй

Хурал даргалагч Ш.Отгонбаяр: Манай компани гадаад, дотоодын 4000 гаруй хувьцаа эзэмшигчидтэй. Бүгд өөр, өөрийн сонгосон брокер диллерын компаниуд дээр бүртгэлтэй байдаг. Төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлахдаа бүртгэлийн өдрийг зарладаг. Тухайн бүртгэлийн өдрөөр тасалбар болгож тархалтын мэдээгээ авч түүний дагуу хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв рүү шилжүүлж хувьцаа эзэмшигчдийн дансанд байрлуулдаг. Компанийн гүйцэтгэх ажил бол энэ үүнийгээ хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнах хуулийн зохицуулалттай. 2023 оны ногдол ашгийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг хуваарилах тухай 2 удаа шийдвэр гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хурал 2 удаа хуралдсан. Энэ маань санхүүгийн тайлагналтай холбоотой байсан гэж хэлж болно. ТУЗ-ийн 2024 оны 02-р сарын 21-ний өдрийн 03 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 4996 төгрөг хуваарилахаар тогтож 2024 оны 04-р сарын 30-нд хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж тараагдсан. Санхүүгийн тайланд залруулга хийгдэж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 07-р сарын 30-ны өдрийн 20 тоот тогтоолоор нэгж хувьцаанд ногдох ноогдол ашгийг 600 төгрөгөөр нэмэгдүүлж нэгж хувьцаанд 5596 төгрөг хуваарилахаар шийдвэрлэснийг 2024 оны 08-р сарын 26-ны өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан. Үүний дагуу нэмэлт ногдол ашиг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжин хувьцаа эзэмшигчдэд тараагдсан гэсэн үг.

Хэлэлцэх асуудал №04 “Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай.

Хурал даргалагч Ш.Отгонбаяр: 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,165,200,00 төгрөгийн орлоготой ажиллаж 589 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 412,4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02-р сарын 12-ны өдрийн хурлаар 2024 оны цэвэр ашгаас ногдол

ашиг хуваарилах асуудлыг хэлэлцэн 366,5 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон хуваарилахаар тогтоол гаргасан. Энэ жил нэгж хувьцаанд 6960 төгрөг хуваарилж байгаа нь компанийн 59 жилийн түүхэнд хамгийн өндөр ногдол ашиг төдийгүй Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас хамгийн өндөр ногдол ашиг өгдөг үзүүлэлтээ баталгаажуулж чадлаа. Өнөөдрийн хуралд ТУЗ-өөс энэ мэдээллээ танилцуулж тогтоолоор албажуулж ногдол ашиг тараах эрх үүсдэг зохицуулалттай. 2024 онд манай компани хамгийн өндөр ашигтай орлоготой компанийн нэг байж, компанийн маань зах зээлийн үнэлгээ 1,8 их наяд төгрөгт хүрч, хувьцааны үнэ 97 хувь өсөж хөрөнгийн зах зээлд тэргүүлэгч компани болсныг та бүхэн мэдэж байгаа байх. Ирэх жилд илүү сайн эдгээр амжилтаа ахиулахын төлөө ТУЗ болон гүйцэтгэх удирдлага хичээж ажиллах болно.

Хэлэлцэх асуудал № 05 Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх тухай

Хурал даргалагч Ш.Отгонбаяр: 2024 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2 бүрэлдэхүүн ажилласан. 2023 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгогдсон ТУЗ-ийн гишүүд 2024 оны 08-р сарын 26-нд хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хүртэл ажилласан. ХЭХ-ийн ээлжит бус хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэн. 2024 онд ТУЗ-ийн гишүүдийг сонгох үйл ажиллагаанд томоохон бодлогын өөрчлөлт хийгдсэн гэж хэлж болно. 2024 оны 4-р сард Өмнөговь аймгийн ИТХ-аар Орон нутгийн өмчийн 51 хувийг төлөөлөх ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах журам батлагдан хэрэгжсэн. Үүний дагуу 51 хувийг төлөөлөх ердийн 3 гишүүнийг төрийн жинхэнэ албан хаагч байхаар журамд тусгагдсаны дагуу миний бие Ш.Отгонбаяр, Б.Мэндбаяр, Э.Бөхбат нар сонгогдсон. 51 хувийг төлөөлөх хараат бус гишүүдийг 2025 оны 4-р сард сонгон шалгаруулалтаар сонгосон. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны хувьд гэвэл 2024 онд 26 удаа танхим болон цахимаар хуралдаж 11 удаагийн эцнээ санал хураалтаар бүрэн эрхийнхээ хүрээнд үнэ тогтоох, бизнес төлөвлөгөө батлах, зөвлөмж чиглэл өгөх тогтоол шийдвэр гаргаж ажилласан болно. Мөн 2024 онд хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2 удаа зохион байгууллаа. Онцлох шийдвэрийн хувьд 2024 онд ажиллагсдын цалинг 2 удаа нэмэгдүүлж, ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах эрхийг хангаж нүүлгэн шилжүүлэлтийг хийх, санхүүгийн үйл ажиллагааг анхаарч тодорхой шийдвэрүүд гаргасан нь ажилчдынхаа нийгмийн асуудал, компанийн эдийн засгийг үзүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн онцлох шийдвэрүүд байлаа. ТУЗ-ийн бүрэн бүрэлдэхүүнээр компанийн үйл ажиллагаа, үндсэн үйлдвэрлэл, тээвэр, цагаан хад дахь үйл ажиллагаатай танилцан тулгамдсан асуудлыг шийдвэрлэн ажилласан болно.

Хувьцаа эзэмшигч У.Цэрэнхорол: За уучлаарай би хоцорч орж ирээд тайлан дутуу сонслоо. Ажилчдынхаа эрүүл мэндийн төлөө нүүлгэн шилжүүлэлт хийсэнд талархаж байгаа. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулсан гэлээ. Энд Цогтцэций сумаас төлөөллийг оруулах ёстой байсан байх. Бас нэгэн асуудал гэвэл манай компани орон нутгийн компани. БЭТ томилогдохоос өмнө бараг 100 хувь орон нутгийн иргэд ажиллаж байсан гэтэл одоо тийм биш болсон. Өмнөговийнхон Хэнтий аймгийн орон нутгийн өмчтэй компанид очоод олноор ажиллах боломжгүй шүү дээ.

Одоо манай компанид Өмнөговь аймгийн яг хэдэн иргэн ажиллаж байгаа тоо мэдмээр байна. Хотоос ирсэн ажилчид унааны зардал, кемп гээд зардал их гардаг. Орон нутгийн иргэдийг ажиллуулах тал дээр болон хүний нөөцийн асуудал дээр ТУЗ анхаарч ажиллах ёстой байх. Бас ажил үүрэг, орон тооны давхцал их байна. Нэг хүний хийдэг ажлыг хоёр хүн хийж байх жишээтэй. Энэ чинь тэгээд хэмнэлт мөн юм уу.

Хурал даргалагч Ш.Отгонбаяр: Өнгөрсөн жил ТУЗ-ийн гишүүдийг сонгох журам аймгийн ИТХ-аар батлагдсан. Уг журмын дагуу хараат бус гишүүдийг сонгон шалгаруулалт явагдсан. Энэ сонгон шалгаруулалтыг аймгийн ИТХ-аас байгуулагдсан ажлын хэсэг буюу төр зохион байгуулдаг. Үүнд ТУЗ оролцдоггүй. Хараат бус гишүүнд ямар ч хүнд нэр дэвших эрхтэй. Цогтцэций сумын иргэд ч нэр дэвших эрхтэй. Нөгөө талаар манай компани нээлттэй хувьцаат компани төдийгүй 51 хувь Өмнөговь аймгийн наян мянган иргэдийн өмч. Түүнд дотор Цогтцэций сумын иргэд багтаж л байгаа. Зөвхөн Цогтцэций гэж туйлширч болохгүй.

Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва: Цэрэнхорол та өөрөө манай компанийн үндсэн ажилтан буюу компанийн үйл ажиллагааг хамгийн сайн мэдэх хүний нэг. ИТХ-ын төлөөлөгч гэдэг үүднээс ийм улс төрийн өнцгөөс асуудалд хандах нь зохисгүй гэдгийг хэлье. Компанийн үйл ажиллагааг сайжруулах, борлуулалтыг нэмэгдүүлэх, үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг технологийн дагуу явуулахад чадвартай боловсон хүчин шаардлагатай болсон. Үндсэн үйлдвэрлэлийг удирдаж ажиллах хүмүүсийг томоохон уурхай, бодлогын яаманд ажиллаж байсан залуучуудыг урьж авчирсан. Үүний үр дүнд манай компанийн уулын ажилд томоохон ахиц өөрчлөлт гарсан. Өмнөговьос нарийн мэргэжлийн чадварлаг боловсон хүчин олддоггүй. Бүгд л томоохон уул уурхайн компанид ажилд орчихсон байдаг. Ажил үүргийн давхардал гэж байна. Өмнө нь манай компанид ямар ажил нь хийдэг нь тодорхой бус, сул цалин аваад явдаг олон хүн байсан нь нууц бишээ. Би энэ бүхнийг цэгцэлсэн, цэгцлэхдээ Өмнөговь аймгийн хүмүүсийг ажлаас чөлөөлөхгүй байхыг хичээдэг. Зөв болгохын төлөө ажиллаж олон дарамт шахалтыг туулаад ажиллаж байгаа.

Хувьцаа эзэмшигч Болдбаатар: Тайлан мэдээлэлтэй танилцлаа. Компанийн үйл ажиллагаа сайн байна гэж дүгнэж байна. ТУЗ өнгөрсөн одоо 37 удаа хуралдаж шийдвэр гаргасан гэж байна. Энэ бол сайн хэрэг. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага сайн хамтарч ажилласан байна гэж үзэж байна. Хүний нөөцийн хувьд сайн байна гэж хэлье. Зорилтот түвшиндээ хүрээгүй ашигт ажиллагааны түвшин 30-40 хувьд байхад боломжийн гэж үзсэн байна. Цаашдаа коксжих нүүрс, сул коксжих нүүрсээ 2024 оных шигээ харьцаагаар гаргаад үнийн өсөлт бууралтын савлагаатай нөхцөлд энэ харьцаагаа бариад явахаар төлөвлөж байгаа юу? гэдгийг асууя. Мөн ТУЗ-ийн гишүүд сардаа ямар хэмжээний цалин авдаг вэ? Орон нутгийн зүгээс хэрхэн дэмжиж ажиллаж байгаа вэ? Тайлангаа сэтгүүлтэй бас танилцлаа. Маш сайн тайлагнасан байна. Уурхайн нөөцөө хүртэл тодорхойлоод гаргасан байна. Коксжих нүүрс, сул коксжих нүүрс гээд ангиллаар нөөцөө гаргасан байна. Маш сайн байна. 2024 онд амжилт дүүрэн ажилласан ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, нийт ажиллагсдад талархал илэрхийлье.

Хурал даргалагч Ш.Отгонбаяр: Орон нутгийн зүгээс бодлогын хувьд дэмжиж ажиллаж байгаа.

Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва: Баярлалаа. Манайх уулын ажил дээрээ технологийн дэвшлийг ашиглаж байгаа. Нөөцөө тодорхойлсон. Коксжих нүүрс олборлоход гарсан нүүрсээ борлуулж орлого олж ажиллаж байгаа. Сул коксжих нүүрсээ мөн адил бирж дээр тавиад борлуулж байгаа. Бохирдолтой ул таазны нүүрсийг компани дээрээ нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулж дотоодын баяжуулах үйлдвэрүүдэд борлуулж байгаа. Энэ дээр нэг асуудал үүсдэг манайх бохирдолтой нүүрс аваад баяжуулаад экспортод гаргах гэхээр зөвшөөрдөггүй. Цаашдаа энэ асуудал зөв шийдэгдвэл бид бүх ангиллын нүүрсээ борлуулж орлогоо нэмэгдүүлэх боломжтой гэсэн үг.

Хэлэлцэх асуудал №06 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай асуудал

Хурал даргалагч, ТУЗ-ийн дарга Ш.Отгонбаяр Өмнөговь аймгийн ИТХ болон том хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороонд ирүүлсэн ТУЗ-ийн гишүүдийн танилцуулгыг хийлээ./Хавсралт/

Хувьцаа эзэмшигч Н.Отгонбаяр: Би компанийн хийсэн ажлыг шүүмжлэх гэж үг хэлээд байгаа юм биш шүү. Үүнийг зөв ойлгоорой. ТУЗ-ийн хараат бус гишүүдийг саяхан сонгосон байна. Энэ мэдээллийн зар хаагуур тавигдав. Хараат бус гишүүнд Цогтцэций сумын төлөөлөл байх ёстой. Үүнийг яагаад анхаарсангүй вэ?

Хурал даргалагч Ш.Отгонбаяр: Орон нутгийн өмчийн төлөөллийг сонгох шалгаруулах ажиллагаа нь компани болон ТУЗ-д огт хамаарахгүй. Сонгон шалгаруулалтыг өмчийн эзэн аймгийн ИТХ-аас томилогдсон ажлын хэсэг явуулсан. Зар мэдээллийг ИТХ болон аймгийн ЗДТГ-ын албан ёсны вэб сайт дээр тавигдсан байсан. Энэ сонгон шалгаруулалт хаанаас ч хэн ч орох нь нээлттэй. Цогтцэций сумын иргэдэд ч мөн нээлттэй.

Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчид /анкет танилцуулгыг хавсаргав/

Ердийн гишүүнд нэр дэвшигч:

1. Шаравын Отгонбаяр
2. Бямбаагийн Мэндбаяр
3. Эрдэнэчулууны Бөхбат
4. Сүрэнхүүгийн Мятавдорж
5. Цэнд-Аюушийн Цэнгэлбаяр
6. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ

Хараат бус гишүүнд нэр дэвшигч:

1. Чинзоригийн Отгонбаяр
2. Батцэцэгийн Батсүрэн
3. Даваадоржийн Дэлгэрцогт

Хувьцаа эзэмшигч У.Цэрэнхорол: ТУЗ-ийн бүрэлдэхүүнд химич, экологийн багш мэргэжилтэй хүн орж байгаа нь сайшаалтай байна. Мэргэжлийн хүний хувьд уурхайн сөрөг нөлөөлөл, тоосжилт агаарын бохирдол, иргэдийн эрүүл мэндийн асуудалд анхаарч ажиллах байх гэж найдаж байна.

Хэлэлцэх асуудал №07: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай

“Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ш.Отгонбаяр ТУЗ-ийн 2025 оны төсвийн төслийг танилцуулж, зарим асуудлыг тодруулж тайлбар хийлээ.

ТУЗ-ийн дарга Ш.Отгонбаяр: Би сая та бүхэнд ТУЗ-ийн 2025 оны төсвийг танилцууллаа. Сүүлийн жилд ТУЗ байнгын ажиллагаатай ажиллаж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөл бол хувьцаа эзэмшигчдийн өмнө компанийн бодлого, менежментийг тодорхойлж ажиллах үүрэг хүлээсэн хамтын шийдвэр гаргадаг бүтэц. ТУЗ-ийн үйл ажиллагааны үндсэн зардал болох цалин, урамшуулал, томилолт, шатахуун, бичиг хэрэг, хурал зохион байгуулахтай холбоотой зардлууд тусгагдсан байгаа. Цаашдаа компанийн үйл ажиллагааг зөв бодлого менежментийг сайжруулж, борлуулалт, ашгийг нэмэгдүүлж ажиллахад ТУЗ нь онцгой анхаарч, илүү өргөн хүрээтэйгээр ажиллах хэрэгцээ шаардлага бий. Энэ хүрээнд олон улсын болон дотоодын зөвлөх үйлчилгээ авахаар төсөвт тусгасан.

Цалин урамшуулал дээр өөрчлөлт орохоор төсөвт тусгалаа. Өмнө нь ТУЗ-ийн гишүүд жилийн цэвэр ашгаас 1 хүртэл хувийн урамшуулал авдаг байсан. 2025 оны 04-р сарын 24-ний өдөр хуралдсан ТУЗ-ийн хурал дээр ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын асуудлыг ярилцаж санал солилцсон. ТУЗ-ийн гишүүдийн санал болон Өмнөговь аймгийн ИТХ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу ТУЗ-ийн гишүүд өндөр хэмжээний урамшуулал авахгүй, компанийн ажиллагсадтайгаа адилхан буюу 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал авах нь зүйтэй гэдэг дээр санал нэгдсэн. Энэ нь шударга, зөв шийдэл гэж үзэж байгаа.

Хувьцаа эзэмшигч н.Сүхбаатар: ТУЗ-ийн өнгөрсөн жилийн ямар хэмжээний төсөвтэй, ямар цалинтай ажилласан вэ?

ТУЗ-ийн дарга Ш.Отгонбаяр: Би түрүүнд хэлсэн. Өнгөрсөн жил ТУЗ-ийн 2 бүрэлдэхүүн ажилласан гээд. 04-р сард хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн төсөв батлагдсан. ТУЗ-ийн гишүүдийн цалин нэлээн хэдэн жилийн өмнө 4,500,000 төгрөгөөр тогтоод түүнээс хойш өнөөдрийг хүртэл өөрчлөлт ороогүй явж байгаа. Өнгөрсөн жил ажилчдын цалинг 2 удаа нэмэхэд ТУЗ-ийн гишүүдийн цалин нэмэгдээгүй. 2025 оны ТУЗ-ийн төсөв дээр ТУЗ-ийн гишүүдийн цалинг компанийн эрх бүхий албан

тушаалтны хамгийн ангиллаар тогтоохоор тусгасан. Нэг үгээр хэлбэл ТУЗ-ийн гишүүдийн цалин дунджаар 50 орчим хувиар нэмэгдүүлэхээр төсөвлөсөн.

Хувьцаа эзэмшигч Б.Цэрэнпагма: Хурал маш сайхан болж байна. Гэхдээ хурлын дэгийг ойлгохгүй байна, хуучин дэгээ батлаад явдаг байсан. Энэ талаар асуумаар байна. Гүйцэтгэх захирлын тайланг сонслоо. Компанийн 2024 оны үйл ажиллагаатай холбоотой тоон мэдээллийг тайлан, самбар энэ тэрнээс харлаа. Уурхайн нөөцөө шинэчилж тогтоосон нь их сайн байна. Нүүлгэн шилжүүлэлт хийгдэж ажилчид эрүүл аюулгүй орчинд ажиллах болсон сайшаалтай. Харин тэнд үлдсэн хөрөнгүүдээ яаж гэж байгаа вэ? Үүнд их санаа зовж байна. Санхүүгийн тайланд анхаарах зүйл байгаа юм байна гэж харлаа. Аудитын дүгнэлт тайланг хэзээ хаана тайлагнах вэ? Өр авлага дүгнэлт нөлөөлсөн гэх шиг боллоо. Яагаад ингээд их өр авлага үүсгээд байна вэ? Энэ талаар анхаарч ажиллах л ёстой байх. Дараагийн асуудал гэвэл ирэх жил компанийн маань 60 жилийн ой болно. Энэ талаар ер ярьсангүй. 60 жилийн ойн бэлтгэл ажил хэзээ эхлэх бэ, төлөвлөгөө нь хэзээ гарах бэ? Хамгийн сүүлийн асуудал гэвэл ахмадын сангийн тухай. Энэ асуудлаар бид захирал болон ТУЗ-д танилцуулсан. Энэ асуудлаар гүйцэтгэх захиралд чиглэл өгсөн гэж сонссон. ТУЗ болон компаниас өнгөрсөн жил ахмадууд биднийг гадаад аялалд явуулж, сувилалд амрааж, өвлийн бэлтгэл хангахад нүүрс өгч, цагаан сараас мөнгөн тусламж үзүүлсэнд талархаж байгаа. Гэхдээ ахмадын сан батлагдаад журамтай болчихвол бүх ахмадууд маань ижил тэгш асуудлаа шийдүүлээд явах боломж бүрдэнэ гэж харж байгаа. Энэ асуудалд онцгой анхаарч өгөөрэй гэж хүсье. Манай компаниас тэтгэвэрт гарсан 40 гаруй ахмадууд бий.

Хурал даргалагч Ш.Отгонбаяр: Таны саналыг сонслоо. Хариулт мэдээлэл өгье.

- Нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой асуудлын хувьд гэвэл ЭТТ болон манай компани хооронд гэрээ бий. Тосгон дээр байгаа манай эд хөрөнгийг 2019 онд үнэлээд 9,8 тэрбум төгрөг олгохоор болсон хэдий ч ЭТТ өнөөдрийг хүртэл энэ төлбөрөөс нэг ч төгрөг өгөөгүй. Аймаг болон ТУЗ, компанийн зүгээс удаа дараа шаардсан. Аймгийн ИТХ дээр энэ асуудал яригдаж ИТХ-аас ажлын хэсэг байгуулагдсан. Орон нутгийн зүгээс нэлээн анхаарал тавьж байгаа.
- Санхүүгийн тайлангийн хувьд би түрүүнд мэдээлэл хийсэн. 2022 онд аймгийн аудитын дүгнэлт өгөхөөс татгалзсан, 2023 оны тайланд сөрөг дүгнэлт өгсөн. 2024 оны тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Хуулийн хугацаанд 3 сарын 17-нд аудитын дүгнэлт гарсан. Хязгаарлалттай дүгнэлтэд нөлөөлсөн гол зүйл нь өр, авлага.
- Өр авлагын хувьд гэвэл 2023 оноос Биржийн тухай хууль хэрэгжиж нүүрс борлуулах нөхцөл өөрчлөгдсөн. Тэгэхээр 2023 оны 01 сарын 01-ний ам нөхцөлөөр хийгдсэн бүх гэрээ зогссон. Маш олон худалдан авагчтай хийсэн гэрээ зогссоноос өр авлага үүссэн. Худалдан авагчидтай холбоо тогтоох, тооцоо нийлэх, тооцоо нийлэхдээ ханшийг хэрхэн тооцох уу гээд асуудлууд нэлээн үүссэн. Өнгөрсөн жил тооцоо нийлсэн зарим худалдан авагч нарын өглөгийг барагдуулах шийдвэрийг ТУЗ-өөс гаргасан. Компани мөн өр, авлага барагдуулах ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа.

- Ахмадын сан болон 60 жилийн ойтой холбоотой тэмдэглэхтэй холбоотой үнэтэй саналыг хүлээж авлаа. Удахгүй ажлын хэсэг байгуулагдаад бэлтгэл ажлаа хангаад явна. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулахтай холбоотой БиДиСеК ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байгаа. Хурлын дэгтэй холбоотой асуудлаар БиДиСеК ХХК-ийг төлөөлж байгаа С.Дөлгөөн тайлбар хийнэ.

С.Дөлгөөн: Компанийн тухай хуулиар ТУЗ нь 40-өөс доошгүй хоногийн өмнө хурлын тов тогтоож шийдвэр гаргадаг. Энэхүү тогтоол шийдвэртээ хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэг, хурлаас гарах шийдвэрийн төсөл, саналын хуудасны загвар тодорхой тусгаж баталгаажуулж брокерын компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлдэг. Та бүхний гарт очсон байгаа хурлын материалд бүгд байгаа.

Хувьцаа эзэмшигч Ц.Минжбадгар: Тайлан мэдээлэл сонслоо. Түүхэнд байгаагүй өндөр ногдол ашиг өгөх гэж байгааг сонсох сайхан байна. Компанийн удирдлага, ТУЗ, уурхайчид бүгд хичээж ажилласанд талархал илэрхийлье. Нэг санал хэлье. Нүүлгэн шилжүүлэлт хийгдсэн нь сайн байна. Шинэ суурьшлын бүсийн төлөвлөлт хийгдсэн. Төлөвлөлтийн дагуу уурхайнуудад оффисын газар олгосон. Төлөвлөгдсөн газраа бүртгүүлж аваарай. Нэг мэдэхэд байхгүй болсон байх вий. Асуулт гэвэл шинэ суурьшлын бүсийн төлөвлөлтийн хүрээнд манайх тэнд ямар бүтээн байгуулалт хийхээр төлөвлөж байгаа, хөрөнгө мөнгө төсөвлөсөн байгаа юу?

Хурал даргалагч Ш.Отгонбаяр: Саналаа хэлсэн танд баярлалаа. Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтад аймаг орон нутгаас анхаарч ажиллаж байгаа. Өнгөрсөн жилүүдэд цахилгаан эрчим хүчний хөрөнгө оруулалтууд хийгдсэн. ЭТТ-той нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын асуудлаар ажлын хэсэг байгуулагдсан байгаа.

Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва: Манай компанийн хувьд бол хүлээсэн үүргээ биелүүлээд нүүлгэн шилжүүлэлтээ хийсэн. Айл өрхүүд шинэ суурьшлын бүсэд нүүгээд ирчихсэн. 2020 оны эхэнд ТУЗ-өөр компанийн бүтэц орон тоо шинэчлэгдсэн. Шинэ бүтцээр Өмнөговь аймаг дахь төлөөлөгчийн газар чиг үүргийн хувьд Өмнөговь аймагтай хөгжлийн асуудлаар ажиллахаар болсон байгаа.

За ингээд хэлэлцэх асуудлаа хэлэлцэж асуулт хариулт явагдаж дууслаа. Одоо 30 минут завсарлаад эргэж хуралдаа ороод санал хураалтаа явуулъя.

Хурал 30 минут завсарлав.

Хурал даргалагч Ш.Отгонбаяр: Хурлаа үргэлжлүүлье. Одоо санал хураалт явагдана. Тооллогын комиссын зүгээс санал хураалтыг хэрхэн зохион байгуулах, саналаа хэрхэн өгөх тухай зөвлөмжийг өгнө.

Тооллогын комиссын дарга С.Дөлгөөн санал хураалт эхэлж буйг мэдэгдэж, хэлэлцэж байгаа нийт 7 асуудлын 1-д нь ердийн аргаар, 1 асуудал буюу ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд кумулятив аргаар санал хураахыг дурдав.

15.20 минутад санал хураалт явагдаж дуусав.

Тооллогын комиссын дарга С.Дөлгөөн санал хураалтын дүнг танилцуулав.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.9999% буюу 49,884,021 ширхэг хувьцаатай 19 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100.00% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.00% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
49,884,021	100.00%	0	0.00%	0	0.00%

2. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.9999% буюу 49,884,021 ширхэг хувьцаатай 19 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100.00% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.00% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
49,884,021	100.00%	0	0.00%	0	0.00%

3. “Тавантолгой” ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.9999% буюу 49,884,021 ширхэг хувьцаатай 19 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100.00% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.00% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
49,884,021	100.00%	0	0.00%	0	0.00%

4. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.9999% буюу 49,884,021 ширхэг хувьцаатай 19 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100.00% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.00% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
49,884,021	100.00%	0	0.00%	0	0.00%

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай Төлөөлөн удирдах Зөвлөлийн шийдвэрийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.9999% буюу 49,884,021 ширхэг хувьцаатай 19 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.9995% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.0005% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
49,883,791	99.9995%	0	0.00%	230	0.0005%

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.9999% буюу 49,884,021 ширхэг хувьцаатай 19 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.9995% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.0005% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
49,883,791	99.9995%	0	0.00%	230	0.0005%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

7. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.9999% буюу 49,884,021 ширхэг хувьцаатай 19 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Шарав Отгонбаяр	10.843%	48,680,902.00

2	Бясбаа Мэндбаяр	10.804%	48,505,132.00
3	Эрдэнэчулуун Бөхбат	10.804%	48,505,232.00
4	Сүрэнхүү Мятавдорж	12.167%	54,623,571.00
5	Цэнд-Аюуш Цэнгэлбаяр	14.379%	64,553,464.00
6	Дашдэмбэрэл Бат-Эрдэнэ	12.167%	54,624,571.00

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Чинзориг Отгонбаяр	10.804%	48,505,432.00
2	Батцэцэг Батсүрэн	10.805%	48,507,562.00
3	Даваадорж Дэлгэрцогт	7.228%	32,450,323.00

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Хурлын шийдвэр:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол №01 -"Тавантолгой" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай

1. Тавантолгой" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн дэлгэрэнгүй тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
2. "Тавантолгой" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад зохих мэдээллийг хувьцаа эзэмшигчид, олон нийтэд журмын дагуу хүргэж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол №02 "Тавантолгой" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт батлах тухай

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 20, 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Тавантолгой" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг баталсугай.
2. Хуралд танилцуулсан дүгнэлтийг цаашид бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

3.Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол №03 Тавантолгой" ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилан олгосон тайланг танилцуулах тухай

1. "Тавантолгой" ХК-ийн 2023 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахтай холбоотойгоор 2024 оны тайлант жилд гүйцэтгэсэн ногдол ашиг тараах үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилан олгосон тухай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хувьцаа эзэмшигчид, олон нийтэд мэдээлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай

4.Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол №03 "Тавантолгой" ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай

1. "Тавантолгой" ХК-ийн 2024 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 11 дүгээр тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу ногдол ашиг хуваарилах, хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол №05 Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай

1. Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
2. "Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлант жилийн хугацаанд гүйцэтгэсэн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол №06 Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох тухай

1. "Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн, хараат бус гишүүдийг хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг кумулятив аргаар тоолж нэгтгэсэн дүнд үндэслэн дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:

1. Шаравын Отгонбаяр /ердийн гишүүн/
2. Бямбаагийн Мэндбаяр /ердийн гишүүн/
3. Эрдэнэчулууны Бөхбат /ердийн гишүүн/
4. Сүрэнхүүгийн Мятавдорж /ердийн гишүүн/
5. Цэнд-Аюушийн Цэнгэлбаяр /ердийн гишүүн/
6. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ /ердийн гишүүн/
7. Чинзоригийн Отгонбаяр /хараат бус гишүүн/
8. Батцэцэгийн Батсүрэн /хараат бус гишүүн/
9. Даваадоржийн Дэлгэрцогт /хараат бус гишүүн/

2. Шинээр сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг холбогдох хууль тогтоомжид заасан эрх, үүргийн хүрээнд идэвх санаачилгатай ажиллахыг үүрэг болгосугай.

7.Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол №07 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай

1. "Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 2024 оны үйл ажиллагааны үр дүнгийн урамшууллын хэмжээг нэгдүгээр, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн мөрдөх цалингийн хэмжээг хоёрдугаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төсвийг гуравдугаар хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цалин урамшууллын дэд хороонд, Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөвт тусгагдсан зардлыг санхүүжүүлж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Хурлын дарга хурлын хааж үг хэлснээр хурал 16.00. минутад дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:



Н.АДЪЯАЦЭРЭН
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

Тэмдэглэл хянасан:



Ш.ОТГОНБАЯР
Хурал даргалагч